

1. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТУГ-ЫН
ЗАХИРАЛ С.ТҮВШИНТӨР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01 зөрчилгүй санал дүгнэлт

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох

бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

“Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Далайн захиргаа” УТУГ-ын захирал С.Түвшинтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.


Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, ажилчдын цалинг төгрөгөөр төлөвлөх, татвар, нийгмийн даатгалын үлдэгдлийг баталгаажуулах, дараа тайлан тооцоог бүрэн хийж байх, зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /САГ-2018/34/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.



“Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2018 оны 2 дугаар сарын 12-ны хооронд хийж 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Энич аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Итгэлтээр ахлуулсан баг хэрэгжүүлэв.


“Далайн захиргаа” УТУГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 09-ний өдөр, залруулсан санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 1/38 тоот албан бичгээр “Энич Аудит” ХХК-д ирүүлсэн байна. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон судалгааны материалуудыг 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдөр ирүүлсэн.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин:

“Далайн захиргаа” УТУГ нь санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Далай ашиглах тухай, Усан замын тээврийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон холбогдох бусад хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Далайн захиргаа” УТУГ нь “Монгол Улсын Эдийн засаг, нийгмийн хөгжилд түлхэц болохуйц далайн тээврийн салбарыг хөгжүүлэх дэлхийн түвшинд хүргэх, мөн Үндэсний хөлөг онгоц багийн гишүүдтэй болж, Монгол Улсын экспортын болон импортын бараа бүтээгдэхүүнийг далайгаар тээвэрлэх, Төрийн далбааг мандуулсан хөлөг онгоцоор далайд тээвэр хийх түүний аюулгүй байдлыг хангах, далайн орчныг хамгаалахад оршино” гэж үйл ажиллагааны зорилгыг тодорхойлсон байна.

“Далайн захиргаа” УТУГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээгээр судалж баримтжуулсан.



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорил, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, АОУС, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Горим сорилыг гүйцэтгэхэд илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг 2.9-д хураангуйлан тэмдэглэв. “Далайн захиргаа” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд “Далайн захиргаа” УТҮГ-ын захирлын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2015 оноос мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцсэн байна.

“Далайн захиргаа” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Далайн захиргаа” УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн “Unicus” програмаар боловсруулан санхүүгийн тайланг бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод аудит

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “Далайн захиргаа” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга:

“Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“Далайн захиргаа” УТҮГ-т 2017 онд Сингапур дахь “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компаниас үйл ажиллагааны санхүүжилт 1,209,570.2 мянган төгрөг, ногдол ашгийн орлого 494,468.9 мянган төгрөг орсон. Урсгал зардалд 753,120.1 мянган төгрөг төлөвлөснөөс 728,319.5 мянган төгрөгийг зарцуулж, 24,800.6 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Өөрийн хөрөнгөөр санхүүжигдэх 724,978.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсанаас 272,058.2 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлсэн байна.


2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд <https://shilendans.gov.mn/org/5802> сайтад “Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг сараар, бүтэн жилээр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг сар бүрээр байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 20 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 10 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэж, үр дүнг гүйцэтгэлийн үе шатанд ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан.

Үр дагаварыг тодорхойлбол: Байгууллагын ажилчдын цалинг ам.доллараар тогтоосон, Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайлангаарх эзний өмчийн дүнгээс 77,839.2 мянган төгрөгөөр бага, үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой ажлын зургийн 19,500.0 мянган төгрөгийн төлбөрийг тайлант хугацааны зардалд тусгасан, ашиглаж буй 736.9 мянган төгрөгийн багаж, төхөөрөмжийг зардалд тусгасан, томилолтын зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй, томилолтын зөрүү 1,054.2 мянган төгрөгийн төлбөрийг дараа тайлангаар тайлагнаж, байгууллагадаа тушаагаагүй зэрэг нийт 26,500.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 20,659.7 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, залруулагдаагүй 5,841.1 мянган төгрөгийн зөрчил тогтоосон нь материаллаг байдлын түвшингөөс бага байна.



2.9 Аудитаар явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл:

2.9.1 Байгууллагын ажилчдын үндсэн цалинг ам.доллараар тогтоосон, Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх мэдээллийн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна

Байгууллагын даргын “Цалингийн санг шинэчлэн тогтоох” тухай 2013 оны 04 дүгээр сарын 09-ний 22 дугаар тушаалаар ажилчдын үндсэн цалинг ам.доллараар тогтоосон байгаа нь 2009 оны 7 дугаар сарын 9-ний “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлж, ажилчдын цалинг үндэсний мөнгөн тэмдэгтээр тогтоох.

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн хэмжээ нь санхүүгийн тайлангаарх Засгийн газрын оруулсан капиталын үзүүлэлтээс 77,839.21 мянган төгрөгөөр бага байгаа нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйл “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл гаргах”-ийн 4.1.3-д “хувь нийлүүлсэн хөрөнгө” заалтыг хэрэгжүүлээгүй байна.


Шийдвэрлэсэн нь: “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу Улсын бүртгэлийн гэрчилгээнд өмчийн өөрчлөлтийг бүртгүүлэх.

2.9.2 Үл хөдлөх хөрөнгө бэлтгэхэд гарсан зардлыг үйл ажиллагааны зардалд тусгасан

Цастбогд ХХК-тай байгуулсан 2017 оны 08 дугаар сарын 25-ны 03 тоот “Зураг төсөл боловсруулах захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ”-ний дагуу гүйцэтгэсэн “Завины өвлийн битүү зогсоолын барилга”-ын ажлын зургийн 19,500.0 мянган төгрөгийн төлбөрийг тайлант хугацааны зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16-ын үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн “өртгийн бүрэлдэхүүн хэсэг...” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бараа үйлчилгээний бусад зардлаас 19,500.0 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн зардал дансруу бүртгэж залруулсан байна.

Юнивишн ХХК-д төлсөн барьцааны төлбөр 282.0 мянган төгрөгийг тайлант хугацааны зардалд тусгасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар заалтын 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалтыг хэрэгжүүлээгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад зардалд тусгасан 282.0 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэж залруулга хийсэн.

2.9.3 Ашиглалтанд байгаа бараа материалыг тайлант хугацааны зардалд тайлагнасан

Утасгүй интернет системийн 367.9 мянган төгрөгийн “wifi BB951” төхөөрөмж, 99.0 мянган төгрөгийн “link SW16” сүлжээний багаж, мөн 270.0 мянган төгрөгийн цагийн бүртгэлийн төхөөрөмжийн төлбөрийг тус тус тайлант хугацааны зардалд тусгасан байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 14.15 дах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бараа үйлчилгээний бусад зардлаас 736.9 мянган төгрөгийн зардлыг бараа материал дансанд бүртгэж залруулсан.

2.9.4 Томилолтын зардлыг заавар журмын дагуу бүртгээгүй байна

Томилолтын урьдчилгаа төлбөрийг тооцооны дансаар дамжуулахгүй зардал дансанд шууд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” зарчим, тус байгууллагын НБББББ-ийн “дараа тайлан гаргагч” заалт, “Байгууллагын үйл ажиллагаанд хөтлөх нягтлан бодох бүртгэл, маягтуудын жагсаалт”-ын зааврын дагуу бүртгэлээ хөтлөөгүй байна.


Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НБББББ-ийн дараа тайлан гаргах зааврын дагуу томилолтын зардлыг тооцооны дансаар дамжуулан бүртгэдэг байх.

Гадаад томилолтын зөрүү болох зочид буудлын төлбөрийн үлдэгдэл 1,054.2 мянган төгрөгийг байгууллагадаа буцаан тушаагаагүй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Зам, тээврийн хөгжлийн яамны ажилтны гадаад албан томилолт болон бусад зардалд 4,377.2 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтын зардлыг тухайн шатны төсвийн захирагчийн эрхийн хүрээнд зарцуулдаг байх.



2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

“Далайн захиргаа” УТҮГ-ын бараа материалын тооллогоор тогтоосон ашиглалтын шаардлага хангахгүй 19,000.0 мянган төгрөгийн шумбагчийн хувцас болон бусад актлах бараа материалын асуудлыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин, шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 26,500.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 20,659.7 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 1,054.2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 4,786.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

“Далайн захиргаа” УТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Релаэнс секюритиз аудит” ХХК нь 2 зөвлөмж өгснөөс бүгд хэрэгжсэн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:


Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг тооцов.

Материаллаг байдлыг тайлант хугацааны үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцох нь тохиромжтой гэж үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 883,092.4 мянган төгрөг төгрөгийн 1 хувь буюу 8,830.9 төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд дахин тооцоход тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 728,319.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 7,283.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

“Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.



“Далайн захиргаа” УТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар,

журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 10 хуудас, хавсралтууд болон санхүүгийн бусад холбогдох материал 20 хуудас тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ЭНИЧ АУДИТЫН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Г.ЧИНТУЯА

БЭЛТГЭСЭН:

ЭНИЧ АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Б.ИТГЭЛТ



3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Энэ Аудит ХХК аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс менежментийн захидалд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 АУДИТЫН ЯВЦАД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН ХАРИУ

Санхүүгийн тайлагналын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
-------------------------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын даргын “Цалингийн санг шинэчлэн тогтоох” тухай 2013 оны 04 дүгээр сарын 09-ний 22 дугаар тушаалаар ажилчдын үндсэн цалинг ам.доллараар тогтоосон байгаа нь 2009 оны 7 дугаар сарын 9-ний “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээн дэх өөрийн хөрөнгийн хэмжээ нь Санхүүгийн тайлангаарх Засгийн газрын оруулсан капиталын үзүүлэлтээс 77,839.21 мянгөн төгрөгөөр бага байгаа нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаал “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр заалт “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл гаргах” зүйлийн 4.1.3-д “хувь нийлүүлсэн хөрөнгө” заалтыг хэрэгжүүлээгүй байна

Эрсдэлүүд

Хууль тогтоомж хэрэгжихгүй байх эрсдэлтэй. Санхүүгийн тайлангийн үнэлгээ, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж


“Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн заалтыг хэрэгжүүлж ажилчдын цалинг үндэсний мөнгөн тэмдэгтээр тогтоох.

“Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын дагуу Улсын бүртгэлийн гэрчилгээнд өмчийн өөрчлөлтийг бүртгүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Байгууллагын удирдлага 2018 онд орлого, зарлагын төлөвлөгөөгөө батлуулахдаа төрийн аудитын байгууллага ажиллагсдын цалинг төгрөгөөр тогтоох талаар судалж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.



Зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
----------------	---------------------------

ҮАГ-ын ажиглалт

Томилолтын урьдчилгаа төлбөр олгомогц тооцооны дансаар дамжуулахгүй зардал дансанд шууд бүртгэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн” зарчим, тус байгууллагын НБББББ-ийн “дараа тайлан гаргагч” заалт, “Байгууллагын үйл ажиллагаанд хөтлөх нягтлан бодох бүртгэл, маягтуудын жагсаалт”, НББ-ийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” заалтыг зөрчиж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны ажилтны гадаад албан томилолт болон бусад зардалд 4,377.2 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй. Иж бүрэн байх, эрх ба үүрэг байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн заалт, байгууллагын НБББББ-д заасны дагуу баримтаа бүрдүүлэн, дараа тайлангийн гүйцэтгэлийг тайлагнадаг байх,

Томилолтын зардлыг тухайн шатны төсвийн захирагчийн эрхийн хүрээнд зарцуулдаг байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 08 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

Г.ЧИНТУЯА

БЭЛТГЭСЭН:

ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР

Б.ИТГЭЛТ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТУГ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Аудит хийгдсэн эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	91,177,697.06	701,270,351.18
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	45,753,423.56	550,333,913.92
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	45,753,423.56	550,333,913.92
31210	Төгрөг	45,376,284.66	13,611,540.76
31213	Арилжааны банк дахь харилцах	45,376,284.66	13,611,540.76
31220	Гадаад валют	377,138.90	536,722,373.16
33	АВЛАГА	289,611.26	92,289,611.26
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	32,610.46	32,610.46
33510	Байгууллагаас авах авлага	257,000.80	92,257,000.80
34	УРЬДЧИЛГАА		19,782,000.00
34600	Урьдчилж төлсөн зардал		282,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		19,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,134,662.24	38,864,826.00
35400	Хангамжийн материал		38,864,826.00
35410	Бичиг хэргийн материал	5,333,500.00	3,220,000.00
35420	Аж ахуйн материал	38,566,368.24	34,410,032.00
35470	Бусад хангамжийн материал	1,234,794.00	1,234,794.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		543,901,989.15
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	190,192,000.00	190,192,000.00
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192,000.00	190,192,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	119,864,255.67	353,709,989.15
39200	Биет хөрөнгө	117,224,255.67	352,389,989.15
39201	Барилга,байгууламж,орон сууц	100,489,787.00	138,573,427.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,766,762.80)	(40,325,493.12)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	118,556,224.00	318,556,224.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,994,609.67)	(106,324,449.63)
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	48,959,146.01	71,213,486.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,423,811.69)	(42,206,011.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,557,519.00	25,277,769.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,153,236.18)	(12,374,963.14)
39300	Биет бус хөрөнгө	2,640,000.00	1,320,000.00
39301	Програм хангамж	5,460,000.00	5,460,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,820,000.00)	(4,140,000.00)

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	401,233,952.73	1,245,172,340.33
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	401,233,953.23	1,245,172,340.33
51100	Засгийн газрын оруулсан капитал	218,716,305.84	218,716,305.84
51200	Хуримтлагдсан үр дүн	182,517,647.39	1,026,456,034.49
51210	Өмнөх үеийн үр дүн	182,517,647.39	182,517,647.39
51220	Тайлант үеийн үр дүн		843,938,387.10
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	401,233,953.23	1,245,172,340.33

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТҮГ
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны аудит хийгдсэн гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	729,590,348.82	1,715,210,335.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	699,616,267.82	1,715,210,335.16
120	Нийтлэг татварын бус орлого	699,616,267.82	1,715,210,335.16
120001	Хувьцааны ногдол ашиг		494,468,860.98
120002	Хүүгийн орлого	942,402.74	5,952,969.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	698,673,865.08	1,209,570,168.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	399,737,265.08	745,678,444.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	298,936,600.00	463,891,723.90
120009	Бусад орлого		5,218,336.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,974,081.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	29,974,081.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	29,974,081.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	704,553,169.05	862,386,061.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	704,553,169.05	862,386,061.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	554,553,169.05	672,386,061.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	241,365,034.86	374,146,951.67
210101	Үндсэн цалин	217,831,092.93	326,956,262.10
210102	Нэмэгдэл	17,163,941.93	31,006,689.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,300,000.00	16,184,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,774,406.52	41,441,335.76
210201	Тэтгэврийн даатгал	21,204,955.86	26,765,806.48
210202	Тэтгэмжийн даатгал	1,120,518.96	3,682,912.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,428,268.64	3,293,689.82

ДАЛАЙН ЗАХИРГАА УТУГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИ

210204	Ажилгүйдлийн даатгал	274,605.73	699,902.56
210205	Эрүүл мэндийн даатгал	2,746,057.33	6,999,024.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,365,460.00	30,859,310.00
210304	Байрны түрээс	21,365,460.00	30,859,310.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,743,373.21	22,627,774.04
210401	Бичиг хэрэг	1,255,356.00	2,341,940.00
210402	Тээвэр, шатахуун	12,235,954.00	16,165,055.90
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	6,252,063.21	4,120,778.14
2105	Нормативт зардал	343,640.00	2,030,000.00
210503	Нормынхувцас, зөөлөн эдлэл	343,640.00	2,030,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,692,261.85	-
210604	Урсгал засвар	6,692,261.85	
2107	Томилолт, зочны зардал	64,815,214.70	57,918,380.00
210701	Гадаад албан томилолт	53,575,485.70	42,996,631.00
210702	Дотоод албан томилолт	5,240,100.00	12,513,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,999,629.00	2,408,399.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,952.52	137,624.65
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,952.52	137,624.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	173,328,825.39	143,224,685.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	152,845,842.38	105,012,188.24
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,482,983.01	38,212,497.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,000,000.00	190,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,000,000.00	190,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	150,000,000.00	190,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	25,037,179.77	852,824,273.78
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	11,835,272.99	8,989,697.71
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	11,835,272.99	8,989,697.71

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАА ДҮГНЭЛТ


V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,483,235.17	17,875,584.39
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	1,483,235.17	17,875,584.39
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	35,389,217.59	843,938,387.10



**“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТУГ
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31**

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн ;оудүн
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн				
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,716,305.84		182,517,647.39	401,233,953.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			843,938,387.00	843,938,387.00
Хөрөнгө шилжүүлсэн				
Элэгдлийн тохируулга				
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	218,716,305.84		1,026,456,034.39	1,245,172,340.23



“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТУГ
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	731,786,102.82	1,727,144,761.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	729,590,348.82	1,714,856,766.16
120	Нийтлэг татварын бус орлого	729,590,348.82	1,714,856,766.16
120001	Хувьцааны ногдол ашиг		494,468,860.98
120002	Хүүгийн орлого	942,402.74	5,952,969.85
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	698,673,865.08	1,209,570,168.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	399,737,265.08	745,678,444.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	298,936,600.00	463,891,723.90
120009	Бусад орлого	29,974,081.00	4,864,767.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,195,754.00	12,287,995.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,195,754.00	12,287,995.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,195,754.00	12,287,995.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	691,694,940.84	941,620,154.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,694,940.84	941,620,154.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	476,868,575.84	728,319,507.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	243,306,303.76	373,606,351.67
210101	Үндсэн цалин	219,772,361.53	333,220,646.67
210102	Нэмэгдэл	17,163,942.23	24,201,705.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,370,000.00	16,184,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,611,138.32	41,441,335.76
210201	Тэтгэврийн даатгал	26,611,138.32	41,441,335.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,109,600.00	30,334,810.00
210304	Байрны түрээс	21,109,600.00	30,334,810.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,075,613.21	22,256,774.04
210401	Бичиг хэрэг	1,177,356.00	2,330,940.00
210402	Тээвэр, шатахуун	12,268,654.00	15,107,155.90
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,879,163.21	4,770,678.14
210404	Ном, хэвлэл	750,440.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		48,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,984,476.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	243,626.00	
210604	Урсгал засвар	4,740,850.00	
2107	Томилолт, зочны зардал	12,391,911.10	57,367,411.00
210701	Гадаад албан томилолт	53,445,485.70	7,43,086,862.00
210702	Дотоод албан томилолт	13,290,400.00	11,775,350.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,646,329.00	2,505,199.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,479,529.85	203,312,824.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,609,574.60	182,230,630.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00	1,500,000.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 ЗӨРЧИЛГҮЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ

ДАЛАЙН ЗАХИРГАА УТУГ–ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИ

210803	Даатгалын үйлчилгээ	98,010.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	115,500.00	298,370.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,500.00	146,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,396,000.00	19,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	84,945.25	137,624.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,920,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,920,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,826,365.00	213,300,647.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	64,826,365.00	23,300,647.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,195,754.00	12,287,995.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,985,517.00	6,367,652.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	1,350,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,645,094.00	3,295,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	150,000,000.00	190,000,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	150,000,000.00	190,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	40,091,161.98	785,524,607.04
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	11,835,272.99	8,989,697.71
145001	Валютын хөншийн зөрүү	11,835,272.99	8,989,697.71
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,786,500.00	272,058,230.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,786,500.00	272,058,230.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,786,500.00	272,058,230.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,786,500.00	272,058,230.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	2,048,772.99	-263,068,532.29
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-1,483,235.17	-263,068,532.29
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР		
25	ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮ	1,483,235.17	17,875,584.39
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	1,483,235.17	17,875,584.39
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	40,656,699.80	504,580,490.36
IX	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	5,096,723.76	45,753,423.56
X	МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	45,753,423.56	550,333,913.92

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

“ДАЛАЙН ЗАХИРГАА” УТУГ
АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2017 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,704,098,499.92	1,219,265,973.51	484,832,526.41	72%
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,704,098,499.92	1,201,390,389.12	502,708,110.80	71%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	753,120,100.00	728,319,507.12	24,800,592.88	97%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,457,100.00	313,271,819.69	-16,814,719.69	106%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	411,408,000.00	373,606,351.67	37,801,648.33	91%
210101	Үндсэн цалин	362,664,000.00	333,220,646.67	29,443,353.33	92%
210102	Нэмэгдэл цалин	30,222,000.00	24,201,705.00	6,020,295.00	80%
210103	Унаа хоолны нэмэгдэл	18,522,000.00	16,184,000.00	2,338,000.00	87%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,255,000.00	41,441,335.76	3,813,664.24	92%
210201	Тэтгэврийн даатгал	28,798,600.00	41,441,335.76	-12,642,735.76	144%
210202	Тэтгэмжийн даатгал	3,291,300.00	0.00	3,291,300.00	0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,114,100.00	0.00	4,114,100.00	0%
210204	Ажилгүйдлийн даатгал	822,800.00	0.00	822,800.00	0%
210205	Эрүүл мэндийн даатгал	8,228,200.00	0.00	8,228,200.00	0%
2103	Ашиглалттын тогтмол зардал	34,308,000.00	30,334,810.00	3,973,190.00	88%
210304	Байрны түрээс	34,308,000.00	30,334,810.00	3,973,190.00	88%
2104	Хангамж, бараа материалын зардал	35,211,200.00	22,256,774.04	12,954,425.96	63%
210401	Бичиг хэрэг	3,300,000.00	2,330,940.00	969,060.00	71%
210402	Тээвэр, шатахуун	24,900,000.00	15,107,155.90	9,792,844.10	61%
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	6,000,000.00	4,770,678.14	1,229,321.86	80%
210404	Ном, хэвлэл	261,200.00	0.00	261,200.00	0%
210406	БҮТЭЗүйлс	750,000.00	48,000.00	702,000.00	6%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,223,200.00	0.00	59,223,200.00	0%
210604	Урсгал засвар	59,223,200.00	0.00	59,223,200.00	0%

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
 4,770,678.14 1,229,321.86
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ДАЛАЙН ЗАХИРГАА УТУГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИ

2107	Томилолт, зочны зардал	91,474,600.00	57,367,411.00	34,107,189.00	63%
210701	Гадаад албан томилолт	76,700,000.00	43,086,862.00	33,613,138.00	56%
210702	Дотоод албан томилолт	7,774,600.00	11,775,350.00	-4,000,750.00	151%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,000,000.00	2,505,199.00	4,494,801.00	36%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	76,240,100.00	203,312,824.65	-127,072,724.65	267%
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний	52,800,100.00	182,230,630.00	-129,430,530.00	345%
210802	Аудит баталгаажуулалт	1,500,000.00	1,500,000.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	1,350,000.00	0.00	1,350,000.00	0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	298,370.00	-298,370.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	146,200.00	-56,200.00	162%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	19,000,000.00	1,000,000.00	95%
210808	Үйлчилгээний хураамж	500,000.00	137,624.65	362,375.35	28%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	226,000,000.00	201,012,652.00	24,987,348.00	89%
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,000,000.00	11,012,652.00	24,987,348.00	31%
213204	Бусад тэтгэмж, урамшуулал	5,000,000.00	6,367,652.00	-1,367,652.00	127%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	1,350,000.00	28,650,000.00	5%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	3,295,000.00	-2,295,000.00	330%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	190,000,000.00	190,000,000.00	0.00	100%
220	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДАЛ	724,978,399.92	272,058,230.00	452,920,169.92	38%
2200	Дотоод эх үүсвэрээр	724,978,399.92	272,058,230.00	452,920,169.92	38%
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	724,978,399.92	272,058,230.00	452,920,169.92	38%
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	0.00	17,875,584.39	-17,875,584.39	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,723,846,463.87	-1,723,846,463.87	
120	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	505,286,597.83	-505,286,597.83	
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	494,468,860.98	-494,468,860.98	
120002	Хүүгийн орлого	0.00	5,952,969.85	-5,952,969.85	
120009	Бусад орлого	0.00	4,864,767.00	-4,864,767.00	

ДАЛАЙН ЗАХИРГАА УТУГ–ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИ

1200041	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	0.00	745,678,444.43	-745,678,444.43	
1200042	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	0.00	463,891,723.90	-463,891,723.90	
1200042	Хөлөг онгоцны бүртгэлийн орлого	0.00	463,891,723.90	-463,891,723.90	
14	Хөрөнгө оруулалтын орлого	0.00	8,989,697.71	-8,989,697.71	
31	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	45,753,423.56	-45,753,423.56	
3101	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	1,704,098,499.92	550,333,913.92	2,254,432,413.84	-32%

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**